

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦСОН
НАМ, ЭВСЛИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН**

**Үндэсний аудитын газар
2020 он**

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

1. Аудитын нэр

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан баталгаажуулах.

2. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-д “Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлнэ.” гэж заасныг үндэслэн Үндэсний аудитын газар нам, эвслийн сонгуулийн зардлыг тайланг хянаж баталгаажуулсан.

3. Аудитын зорилго

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлнэ.

4. Аудитын хамрах хүрээ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамарсан.

5. Арга зүй

Аудитын ажлыг гүйцэтгэхэд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/55 дугаар тушаалаар баталсан “Сонгуулийн зардлыг тайлагнах заавар, аргачлал”-ыг үндэслэн нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвслээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

6. Үндсэн мэдээлэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 29 тойрогт 13 нам, 4 эвслийн 485 иргэн нэр дэвшсэн байна. Үүнд,

| № | Нам, эвслийн нэр | Нам | Эвсэл | Нэр дэвшигчид |
|---|---|-----|-------|---------------|
| 1 | Монгол Ардын нам | 1 | | 76 |
| 2 | Ардчилсан нам | 1 | | 76 |
| 3 | Та бидний эвсэл /МАХН-ИЗНН-МУНН/ | | 1 | 74 |
| 4 | Шинэ нам, Бүгд Найрамдах нам, Үнэн ба Зөв нам, Монголын Үндэсний Ардчилсан намын "Шинэ эвсэл" | | 1 | 72 |
| 5 | "Зөв хүн электорат" эвсэл | | 1 | 53 |

| | | | | |
|----|------------------------------------|-----------|----------|------------|
| 6 | Сахигтун ! үндсэн хуулийн 19 эвсэл | | 1 | 34 |
| 7 | Монголын Ногоон нам | 1 | | 15 |
| 8 | Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам | 1 | | 13 |
| 9 | Хөгжлийн хөтөлбөр нам | 1 | | 7 |
| 10 | Ард түмний нам | 1 | | 1 |
| 11 | Ард түмнээ хайрлая нам | 1 | | 1 |
| 12 | Ард түмний олонхий засаглал нам | 1 | | 24 |
| 13 | Эх орончдын нэгдсэн нам | 1 | | 1 |
| 14 | Зон олны нам | 1 | | 30 |
| 15 | Гэр хороолол хөгжлийн нам | 1 | | 4 |
| 16 | Дэлхийн Монголчууд нам | 1 | | 3 |
| 17 | Их Эв нам | 1 | | 1 |
| | ДҮН | 13 | 4 | 485 |

Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэлээс сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 15 нам, эвслийн дансны эхний үлдэгдэл 0.1 сая төгрөг байсан ба зардлын хураангуй тайлангаар нийт 8,185.1 сая төгрөгийн орлого, 9,579.6 сая төгрөгийн сонгуулийн үйл ажиллагааны зардал тайлагнаж, харилцах дансны үлдэгдэл 4.8 сая төгрөг, төлөгдөөгүй өр төлбөр 1,398.5 сая төгрөг байна.

Сонгуульд оролцсон нам, эвсэлд 7 хуулийн этгээд 98.7 сая төгрөг, 1744 иргэн 5,897.2 сая төгрөг, нийт 5,995.9 мөнгөн болон мөнгөн бус хандив өгсөн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/23 дугаар тушаалаар Монгол Улсын Их Хурлын сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 5,900.0 сая төгрөгөөр тогтоосон ба сонгуульд оролцсон нам, эвслүүд тогтоосон хэмжээнд зардал гаргасан байна.

7. Сонгуулийн зардлын дансны орлого, зардал

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3-д “ Нам эвсэл, санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан хугацаандаа ирүүлсэн 15, тайлангаа ирүүлээгүй 2 нам байна.

Нам, эвслийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 8,185.1 сая төгрөгийг орлогын ангиллаар харуулбал. Үүнд:

| ОРЛОГЫН АНГИЛАЛ | ОРЛОГО /сая төгрөг/ | | | | НИЙТ | |
|--------------------------------------|---------------------|----------------|----------|------------|--------------|----------------|
| | Тоо | Мөнгөн | Тоо | Мөнгөн бус | Тоо | Дүн |
| Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө | 8 | 2,182.1 | | | 8 | 2,182.1 |
| Хуулийн этгээдийн хандив | 7 | 98.8 | 1 | 7.0 | 8 | 105.8 |
| Иргэний хандив | 1,744 | 5,897.2 | | | 1,744 | 5,897.2 |
| ДҮН | 1,759 | 8,178.1 | 1 | 7.0 | 1,760 | 8,185.1 |

Нам, эвсэл сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 9,579.6 сая төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 9,458.0 сая, бусад зардалд 121.6 сая төгрөг зарцуулжээ. Үүнд:

| ЗАРДЛЫН АНГИЛАЛ | | МӨНГӨН ДҮН /сая төгрөг/ |
|-------------------------|---|------------------------------------|
| НИЙТ ЗАРДЛЫН ДҮН | | 9,579.6 |
| 2.1 | Сонгуулийн зардлын дүн | 9,458.0 |
| 2.1.1 | Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах | 996.5 |
| 2.1.2 | Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах | 63.4 |
| 2.1.3 | Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал | 280.1 |
| 2.1.4 | Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал | 211.7 |
| 2.1.5 | Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал | 1,492.8 |
| 2.1.6 | Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал | 5,766.1 |
| 2.1.7 | Цахим орчин ашиглах зардал | 171.7 |
| 2.1.8 | Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал | 475.7 |
| 2.2 | Бусад зардлын дүн | 121.6 |

Мөн Ардчилсан нам 1,360.0 сая төгрөг, Та бидний эвсэл 38.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

8. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив:

Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу, буцах хаяг тодорхойгүй зэрэг шалтгаантай 123 иргэн, хуулийн этгээдийн 101.1 сая төгрөгийн хуулиар зөвшөөрөөгүй хандив тайлагнаснаас 98 иргэн, хуулийн этгээдийн 97.8 сая төгрөгийн хандивыг буцаасан, 20 иргэний 0.2 сая төгрөгийн хандивыг улсын орлогод шилжүүлсэн, 5 иргэний 3.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

9. Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:

Аудитын хуулийн этгээдүүд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/55 дугаар тушаалаар баталсан “Сонгуулийн зардлыг тайлагнах заавар, аргачлал”-ын дагуу аудит хийж баталгаажуулсан тайланг ҮАГ дахин хянаж аудитын явцад нийт 60.0 сая төгрөгийн алдааг залруулсан.

Нам, эвсэл сонгуулийн зардлын тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Их эв нам, Хөгжлийн хөтөлбөр нам сонгуулийн зардлын явцын тайлан болон эцсийн тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлээгүй;
- Хандивын эх үүсвэр, нэр, регистрийн дугаар тодорхойгүй 5 иргэний 3.1 сая төгрөгийг буцаан шилжүүлээгүй зарцуулсан;
- Зарим нам, эвсэл үйл ажиллагааны дансаар нэр дэвшигчийн хандив болон өөрийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулсан, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд хуримтлуулсан мөнгөн орлогыг намын үйл ажиллагааны

дансанд шилжүүлэн зарцуулсан, нэг намын нэг тойрогт дэвшсэн нэр дэвшигчид өөрийн зардлын дансанд хуримтлагдсан орлогоос намын дансанд нэгдсэн байдлаар шилжүүлэн зарцуулсан;

- Мөнгөн бус хандив өгсөн хандивлагч нь нэр дэвшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй бичгээр гэрээ байгуулаагүй байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5-д “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу нам, эвслийн зардлын дансны хуулгыг ирүүлсэн байна.

10. Аудитын дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцосн 15 нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг аудитын хуулийн этгээдүүд үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн гэж дүгнэлт гарсан байна.

11. Зөвлөмж

Сонгуулийн ерөнхий хороонд:

- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, иргэдийн боловсролыг дээшлүүлэх талаар тасралтгүй мэдээ, мэдээллийг хүргэж байх.
- Нам, эвслийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн сонгуулийн зардлын тайлан гаргах, баталгаажуулах, улсын хэмжээнд нэгтгэж тайлагнах, тайланг хүргүүлэх, нийтэд мэдээлэх зэрэг үйл ажиллагааг хуулийн дагуу, хариуцлагатай, үнэн зөв хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.

Сангийн яаманд:

- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн нам, эвсэлд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21, 25, 27-дахь заалт хэрэгжүүлж холбогдох арга хэмжээ авах.

**Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн
сонгуулийн нийт орлого**

/мянган
төгрөг/

| № | Нам, эвсэл нэр | Нийт орлогын дүн | Үүнээс: Орлогын ангилал | | | |
|-----------------|-----------------------------------|--------------------|-------------------------------------|---------------------------|-------------------------------------|-------------------|
| | | | Нам эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө | Иргэний өгсөн нийт хандив | Хуулийн этгээдийн өгсөн нийт хандив | |
| | | | | Мөнгөн хандив | Мөнгөн хандив | Мөнгөн бус хандив |
| 1 | Монгол Ардын нам | 5,528,448.9 | - | 5,467,697.5 | 60,751.4 | - |
| 2 | Ардчилсан нам | 2,078,130.0 | 2,075,120.0 | 3,010.0 | - | - |
| 3 | Та бидний эвсэл | 139,835.0 | - | 139,835.0 | - | - |
| 4 | Дэлхийн монголчууд нам | 6,280.0 | 4,481.0 | 1,799.0 | - | - |
| 5 | ШИНЭ эвсэл | 57,315.2 | 34,031.0 | 23,284.2 | - | - |
| 6 | Монголын Ногоон нам | 40.0 | - | 40.0 | - | - |
| 7 | Зөв хүн электорат эвсэл | 169,692.5 | 53,440.0 | 109,252.5 | - | 7,000.0 |
| 8 | Сахигтун! Үндсэн хуулийн 19 эвсэл | 33,969.0 | 15,000.0 | 18,969.0 | - | - |
| 9 | Ард түмний нам | 20.0 | 20.0 | - | - | - |
| 10 | Ард Түмний Олонхийн Засаглал нам | 50.0 | - | 50.0 | - | - |
| 11 | Ард түмнээ хайрлая нам | - | - | - | - | - |
| 12 | Гэр хорооллын хөгжлийн нам | 20.0 | 20.0 | - | - | - |
| 13 | Зон олны нам | - | - | - | - | - |
| 14 | Их Эв нам | - | - | - | - | - |
| 15 | Хөгжлийн хөтөлбөр нам | - | - | - | - | - |
| 16 | Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам | 100.2 | 20.2 | 80.0 | - | - |
| 17 | Эх Орончдын Нэгдсэн нам | 171,150.0 | - | 133,150.0 | 38,000.0 | - |
| Нийт дүн | | 8,185,050.8 | 2,182,132.2 | 5,897,167.2 | 98,751.4 | 7,000.0 |

| | | | | | | | | | | | | | |
|-----------------|-----------------------------|--------------------|------------------|-----------------|------------------|------------------|--------------------|--------------------|------------------|------------------|-----------------|------------------|------------------|
| 14 | Их Эв нам | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 15 | Хөгжлийн хөтөлбөр нам | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 16 | Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам | 80.2 | - | - | - | 80.0 | - | - | - | - | - | - | 0.2 |
| 17 | Эх Орончдын Нэгдсэн Нам | 171,150.0 | 550.0 | - | - | - | 170,592.0 | - | - | - | - | - | 8.0 |
| Нийт дүн | | 9,579,671.6 | 996,458.2 | 63,425.3 | 280,090.0 | 211,730.5 | 1,663,533.4 | 5,595,468.0 | 126,000.0 | 100,000.0 | 90,378.8 | 331,000.0 | 121,587.3 |

